

**СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР 2025 ОНЫ ХАГАС ЖИЛ**

2025 оны 12 дугаар сарын 04

Номгон

Д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4
	Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал		Хэрэгжилттэй байдал
1	1.Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	Хангайн бүсийн сургалт 2025 оны 03 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд Өвөрхангай аймагт зохион байгуулж тус сургалтад байгууллагын 4 албан хаагч оролцсон. Биеийн тамир Улсын хорооноос 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулсан Биеийн тамир, спортын тухай /шинэчилсэн/ хуулийн хэрэглээний цахим сургалтад байгууллагын 52 албан хаагч хамрагдан оролцсон.Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн хөгжлийн дэмжих зорилгоор "БОЛОМЖИЙГ БҮГДЭД" сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд ажлын байранд зохион байгуулж тус сургалтад нийт 40 албан хаагчийг хамруулан оролцуулсан.2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр " Эрүүл зөв хооллолт-Эрүүл мэнд" сэдвийн хүрээнд Насан туршийн суралцахуйн төвийн сургагч багш Б.Сэлэнгэ, "Хөдөлмөрийн харилцаа ба хөдөлмөр эрхлэлт" сэдвийн хүрээнд Аймгийн ЗДТГ-ын Хууль, Эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, Монополын газрын улсын байцаагч Б.Ану, "Жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого, төлөвлөлт" сэдвийн хүрээнд Хүний эрхийн үндэсний комиссын Баянхонгор аймаг дахь референт Б.Содонцэцэг нар өгч ажиллалаа. Стандарт хэмжилзүйн газраас 2025 оны 04 дүгээр сарын 01-04-ны өдрүүдэд зохион байгуулсан"МNS ISO 9001:2016-Чанарын менежментийн тогтолцоо, шаардлага стандарт", "MNS ISO19011:2020 менежментийн тогтолцоонд аудит явуулах заавар" сэдэвт чадамжийн гэрчилгээ олгох сургалтад 2 албан хаагчийг хамруулсан."Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"- ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Хүндэлбье, энэрье" уриан дор нийт албан хаагчдад Ёс зүйн нөлөөллийн ажил, сургалт зохион байгууллаа.Газрын даргын баталсан "Албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах 2025 оны төлөвлөгөө"- ний хэрэгжилтийн хүрээнд нийт 43 удаагийн дотоод сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 1103 албан хаагчийг сургалтад хамруулан ажиллалаа.Мөн Дархан-Уул аймагт зохион байгуулсан "Биеийн тамир, спортын салбарын улсын зөвлөгөөнд 28 албан хаагчийг хамруулан ажиллалаа.	100%
2	2.Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын	Тайлант хугацаанд гадаад сургалт зохион байгуулагдаагүй.Биеийн тамир, спортын улсын хороо, Япон улсын Шизуока мужийн Яйзу хоттой биеийн тамир, спортын	90%

1	2	3	4
	болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	салбарт хамтран ажиллах төрийн албан хаагчдын мэргэжил дээшлүүлэх биеийн тамирын арга зүйчдийг богино хугацааны сургалтад хамруулах хамтран ажиллах гэрээ байгуулж 2026 онд хэрэгжүүлэхээр хүлээгдэж байна.	
3	3.Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх зарцуулсан чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр хөрөнгө зарцуулагдаагүй.Тайлант хугацаанд албан хаагчдын шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор түр ажиллаж байсан 2 албан хаагчийг чөлөөлж хүүхэд харах чөлөөтэй байсан 2 албан хаагч ажилдаа буцаж орсон. Төрийн үйлчилгээний 4 албан хаагчийг ажилд шинээр томилсон. 1 албан хаагч эрүүл мэндийн шалтгаанаар түр, 2 албан хаагчийг өөрийн хүсэлтээр, 16 албан хаагчийг Төсвийн тухай хууль болон Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор цалингийн сангийн санхүүжилтгүй болсон тул үүрэг ажлаас чөлөөлсөн.Мөн Төрийн захиргааны албан тушаалын 3 орон тооны зарын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлэн ажилласан боловч сул орон тоо нөхөгдөөгүй байна.	100%
4	4.Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Албан хаагчдын цалинг Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 тогтоол, үйл ажиллагааны үр дүн урамшууллыг Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ыг удирдлага болгон 2025 оны 1,2,3,4-р улирлын үр дүнгийн урамшуулалд 68,4 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг олгож ажилласан.	100%
5	5.Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлж, албан хаагчдыг шаардлагатай ширээ сандал, компьютер принтер зэрэг тоног төхөөрөмжөөр ханган ажиллаж байна.	90%
6	6.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	"Дэрсэл" эмнэлэг, "Соба мамба" дацан уламжлалт эмнэлэгийн эмч нар 16 албан хаагчдад эрүүл мэндийн сургалт хийж, судсаар оношилж, зөвлөгөө өгсөн.Байгууллагын албан хаагчдыг Бүсийн оношилогооны төвийн үзлэгт 1 удаа хамруулсан ба энэхүү оношилогоонд бүх албан хаагчийг хамруулан ажиллалаа.	100%
7	7.Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	Салбартаа тогтвор суурьшилтай ажилласан 1 албан хаагчид 7,1 сая төгрөгийн тэтгэмж,"Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу 1 албан хаагчид 8.1 сая төгрөгийн урамшуулал, "Дэлхийн гэр бүлийн өдөр", "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан албан хаагчдын	100%

1	2	3	4
		хүүхдүүдэд нийт 2.5 сая төгрөгийн гарын бэлгийг олгосон. Мөн ар гэрт гачигдал тохиолдсон 2 албан хаагчид 780 мянган төгрөгийн мөнгөн тусламж олгож ажилласан.	

ХЯНАСАН:
 БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
 ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ: *Э. Бүтмүсүрэн* Б.ХҮРЭЛЧУЛУУН



НЭГТГЭСЭН:
 АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН *Э. Бүтмүсүрэн* Э.ДОЛЖИНСҮРЭН